

МӨНГӨ ӨСГӨХ ТУХАЙ


Б. АЧБОЛД, Д. ДОТНО, МІСС СУДАЛГААНЫ БАГ

*“Өөдлөх хүнд санах, сэрэх, хэмнэх гурав
Уруудах хүнд унтах, идэх, мартагч гурав.”*

Мөнгөө яаж өсгөх вэ? Толгой тархинд халгаатай энэ асуултанд хариулах уул нь тийм ч хэцүү биш. Хүн зарцуулснаасаа илүүг олох хэрэгтэй. Эсвэл олсноосоо багыг зарах хэрэгтэй. Тэгээд ашгаа хуримтлуулах хэрэгтэй. Хуримтлуулахгүй, хадгалахгүй бол мөнгө өсөхгүй.

Харин яаж, ямар хэлбэрээр хадгалах вэ? Мөнгөө гудсан доороо хийж болно. Харамсалтай нь ингэж хадгалсан мөнгө өсөхгүй. Юмны үнэ нэмэгдэх болгонд худалдан авах чадвар нь буурна. Тэгвэл мөнгөө хадгаламжийн дансанд хийх ёстой юу? Хувьцаа, бонд авах ёстой юу? Байр авах ёстой юу?


Үүний хариулт таны даах эрсдэлээс хамаарна. Өндөр өгөөж голдуу өндөр эрсдэлийг дагуулдаг. “Бага эрсдэлтэй, өндөр өгөөжтэй” сонголт гэж бараг байхгүй. Байгаа бол зах зээлийн өрсөлдөөн үгүй хийгээд өгнө. Гудсан доорх мөнгө эрсдэл багатай ч өсөхгүй. Ирээдүйтэй залуу компаний хувьцаа уулын оргилд хүрч болох авч жалга уруудаад өнхөрч бас болно. Эрсдэл бол таны төлөх төлбөр. Үнэгүй юм гэж үгүй.



1970 онд Америкт хөрөнгө оруулсан 1000 ам доллар өнөөдөр хэд болох байсныг харъя. S&P 500 индекс (Америкийн хамгийн өндөр үнэлгээтэй 500 компаний хувьцааны багц)-ийн дагуу хөрөнгө оруулсан бол өнөөдөр 13,707 доллартай, харин мөнгөө инфляциас хамгаалах төдий явсан бол 6,021 доллартай сууж байх

нь. Гэхдээ хадгаламжийн данс тогтвортой байхад S&P индекс дээшээ доошоо ямар их савласныг харж болно. 2005 онд 1 сая төгрөгөөр Монголын Хөрөнгийн Бирж дээрхи өндөр үнэлгээтэй 20 компанийн хувьцааны багцыг авсан бол өнөөдөр 20 сая төгрөгтэй болох байсан бол инфляцаас л мөнгөө хамгаалсан бол 1.9 саятай болно. Харин жилд 5 хувийн хүүтэй хадгаламжийн дансанд та мөнгөө хадгалсан бол одоо 5.8 саятай болох байсан ч энэ хугацаанд дампуурсан банкуудын нэгийг нь сонгосон бол бүх мөнгөө алдах байсан. Аль нэг мөчид хөрөнгийн зах зээлд оруулсан мөнгө хурдтай өсч ч болно, гэнэт унаж ч болно. Ийм л эрсдэл байна.

2005 онд 1 сая төгрөгөөр хөрөнгө оруулсан бол...



Хэр их эрсдэл үүрэх вэ гэдэг бол таны сонголт. Та амар түвшин амьдрах сонирхолтой байж болно. Эсвэл мөрийтэй тоглох ч дуртай байж болно. Гэхдээ ямар ч хүн насандаа тохируулж эрсдлээ бодвол зохино. Залуу хүнд алдсанаа нөхөж амьдралаа шинээр эхлүүлэх цаг боломж байдаг бол нас ахих тусам энэ боломж үгүй болно. Тиймээс залуудаа бага дунд зэргийн эрсдлээс эмээлгүй хөрөнгөө өсгөхийг чармайж, харин бууралтаж буян суух тусмаа хөрөнгөө илүү хамгаалах хэрэгтэй.

Ямар ч хөрөнгө оруулагчийн хувьд эрсдлээс хамгаалах үндсэн арга бол хөрөнгөө аль болох олон хэлбэр төрлөөр тараан байршуулж *хөрөнгийн багцтай* болох юм. Жишээ нь нийт хөрөнгийгхөө 10 хувийг бэлэн мөнгөөр хадгалж, 20 хувийг засгийн газрын бонд, 10 хувийг компаний бонд, үлдсэн 60 хувийг Топ-20 индексийн бүх компаниудын хувьцаанд хөрөнгө оруулж болно. Энэ багц эрсдэлтэйд тооцогдох боловч бүх мөнгөөрөө нэг компаний хувьцаа авахаас

хамаагүй бага эрсдэлтэй юм. Монголд хөрөнгийн зах зээл хөгжиж, өмнөхөө бодвол хөрөнгө оруулалт хийх боломжууд ч нэмэгдсээр байна.

Үл хөдлөх хөрөнгө авах нь хөрөнгө оруулалтын бас нэг хэлбэр. Байшин сав нүдэнд үзэгдэж, гарт баригддаг болохоор ч тэр үү, зарим хүмүүс үл хөдлөх хөрөнгийг бага эрсдэлтэй гэж үздэг. Гэхдээ мэдээж байшин шатаж болно. Дээр нь (хамгийн гол нь) үл хөдлөх хөрөнгийн үнэ бас дээшээ доошоо савладаг. Үүний жишийг бид саяхан харсан (Америк, Ирланд, Исланд... одоо Хятад). Монголд байрны үнэ сүүлийн жилүүдэд их өссөн гэдгийг санаж болгоомжлоход илүүдэхгүй болов уу.